



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 285

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, 2020 оны 111 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 48,401,659.00 (дөчин найман сая дөрвөн зуун нэг мянга зургаан зуун тавин есөн) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу ашиглах хугацаа, үнийг 6,000,000.00 (зургаан сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, Хил хамгаалах ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Мөнхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Автомашины улсын дугаарыг улсын бүртгэл, татвар төлөгчөөс бүртгэлээс шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133081365

ТӨБЗГ тогтоол-/2021

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2021 оны 26 дугаар сарын 28 өдрийн
 285 дугаар тогтоолын хавсралт

**"МОНГОЛПРОСЦВЕТМЕТ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
 ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ**

д/д	Тээврийн хэрэгслийн нэр, улс, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуризмтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Ашиглах хугацаа (жил)
1	Хово 4729 ХЭА, арал-Lzz5elmd67a136532	2008	48,401,659.00	48,401,659.00	0.00	6,000,000.00	1
	НИЙТ ДҮН		(дөчин найман сая дөрвөн зуун нэг мянга зургаан зуун тавин ес)			(дөрвөн сая)	